

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2014 ОНЫ 5 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 5 дугаар сард 2 удаа хуралдаж 5 асуудал хэлэлцэн 17 тогтоол баталлаа.

- Тус аймгийн Сайханы хөтөл, түүний орчмын газар нутгийн байгалийн унаган төрхийг хамгаалах, хил хамгаалахад дэмжлэг үзүүлэх, орон нутгийн түүх, уул усны өвөрмөц тогтоц үзэсгэлэнт байгалийг хадгалах, хамгаалах зорилгоор аялал жуулчлалын бүс болгон, амралт, аялал жуулчлалаар зорчигсдод үзүүлэх журмыг батлан гаргалаа.

- 2014 онд 90 жилийн түүхэн ойгоо тэмдэглэх гэж буй зарим сумдын хариуцаж буй салбартаа хөдөлмөр, бүтээлийн өндөр амжилт гаргасан иргэдийг Төрийн дээд одон, медалиар шагнуулахаар уламжиллаа.

Аймгийн "Сэлэнгэ-Ногоон бүс" хөтөлбөрийн хүрээнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид өөрсдийн хүч хөрөнгөөр Сайханы хөтөлд 3 га газарт мод тарьж, ойжуулалт хийлээ.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанаас Жавхлант, Хушаат, Сант сумдад ажиллаж хурал, түүний Тэргүүлэгчдийн үйл ажиллагаа, бодлого шийдвэртэй танилцаж арга зүйн зөвлөгөө өглөө. Мөн дээрх сумдын иргэдэд Үндсэн хууль болон бусад хууль, тогтоомжуудаар олгогдсон Хүний эрх, үүргийн талаар сургалт зохион байгууллаа.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

"Гэр бүлийг дэмжих жил"-ийн нээлтийн үйл ажиллагааг Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжил болон хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, "Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил"-ийн ажлын хүрээнд гэр бүлүүдийн аймаг, сум, орон нутгийнхаа хөгжилд оруулсан хувь нэмрийг үнэлэх, нийтэд сурталчлах, амьдралын зөв хэв маягийг залуу хойч үедээ өвлүүлэн үлдээх зорилгоор манай аймаг "Гэр бүлийн үнэ цэнэ" аймгийн зөвлөгөөнөөр эхлүүлжээ. Олон улсын "Гэр бүлийн өдөр"-өөр зохион байгуулсан тус арга хэмжээг аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс, Дэлхийн зөн олон улсын байгууллага хамтран зохион байгууллаа.

Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас санаачлан "Ил тод, ээлтэй, хариуцлагатай үйлчилгээ" сэдэвт авлигын эсрэг олон нийтийн хэлэлцүүлгийг 2014 оны 5 сарын 8-ны өдөр зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт аймгийн 5 бүс, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөл, иргэд оролцлоо. Хэлэлцүүлгийн үеэр аймгийн Засаг дарга төрийн үйлчилгээний өнөөгийн байдал, авч хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээ, цаашид анхаарах асуудлын талаар танилцуулж, нийт оролцогчдын дунд:

1.Авлига үүсч буй шалтгаан нөхцөл, өнөөгийн байдлыг та юу гэж бодож байна вэ?

2.Төрийн байгууллагын зүгээс авлигын эсрэг юу хийгээсэй гэж бодож байна вэ? гэсэн асуулт бүхий хуудсаар иргэдийн санал хүсэлтийг авч, аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас хэлэлцүүлэгт оролцогчдын хэлсэн санал, үйл явцыг харуулсан тусгайлсан нэвтрүүлгийг бэлтгэж сум, тосгон бүрт хүргүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас ард иргэдийнхээ дуу хоолойг сонсож, тулгамдсан асуудлыг нь шуурхай шийдвэрлэн, гарсан санал санаачлагыг нь ажилдаа тусган ажиллах үүднээс орон нутгийн "Миний Монгол" телевизтэй хамтран "Иргэдээ сонсьё" нэвтрүүлгийг зохион байгуулж эхэлсэн. Тус нэвтрүүлгийг тогтмолжуулж, илүү олон байгууллагыг хамруулан, ард иргэдэд

тулгамдаж байгаа асуудлыг салбар бүрээр сонсон, шийдвэрлэж ажиллахын тулд 7 хоног бүрийн 5 дахь өдрийн 18.30 минутаас “Иргэдээ сонсьё” шууд нэвтрүүлгийг явуулж байхаар шийдвэрлэн, үйл ажиллагааг тогтмолжуулаад байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, ОХУ-ын Хиагтын район, “Хлебо булочны” байгууллагатай хамтран талх нарийн боовны сургалт, үзэсгэлэн худалдаа, Хайтан цэцгийн клубын үзэсгэлэнг зохион байгууллаа. Сэлэнгэдээ талх, нарийн боовны үйлдвэрлэлийг өргөжүүлж, Дархан-Уул аймгийн Зах зээлд өөрсдийнхөө өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор энэхүү арга хэмжээг зохион байгууллаа.

Оросын үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэсэн талх, нарийн боов, цэцгийн үзэсгэлэн худалдаа ард иргэдийн эрэлт хэрэгцээнд бүрэн нийцэж, худалдан авагч олонтой байлаа. Хиагт хотын “Хлебо булочны” байгууллагын хүнсний технологич 5 багшийг урьж аймгийнхаа талх нарийн боов үйлдвэрлэгчдэд 2 өдрийн сургалт зохион байгуулсанд үйлдвэрлэгчид сэтгэл хангалуун байлаа. Үзэсгэлэн худалдаанд аймгийн Засаг даргын урилгаар Хиагтын районы дарга А.В.Буянтуев тэргүүтэй зочид төлөөлөгчид, Хиагт хотын удирдлагууд төдийгүй, ОХУ-ын Сибирицка ансамбалын уран бүтээлчид хүрэлцэн ирж оролцлоо.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хүнсний дэлгүүр, хүнсний зах, нийтийн хоолны үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжийн эзэд, менежерүүдэд “Хүнсний тухай”, “Хүнсний бүтээгдэхүүний байдлыг хангах тухай хууль”, “Худалдаа үйлчилгээнд тавигдаж байгаа шинэ шаардлага” сэдэвт сургалтыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, аймгийн Засаг даргын Тамгын газар, Монголын Хүнсний зах, эздийн Холбоо, МУИС-ийн Худалдааны сургуультай хамтран олон улсын худалдаа, үйлчилгээний чиг хандлага, Монгол Улсын худалдааны салбарын бодлого, худалдаа, үйлчилгээний орчин үеийн шаардлага, үндсэн зарчим, дүрмүүд, Худалдааны салбарын хууль эрх зүйн орчин, стандарт, хүнсний худалдааны эрсдэл, эрсдэлд нөлөөлж буй хүчин зүйл, Худалдааны сэтгэл зүй, худалдааны ажилчдын соёл, харилцааны хандлагууд, борлуулалтыг нэмэгдүүлэх арга, боломжууд, Худалдааны төвийн төлөвлөлт, тавигдах үндсэн шаардлагууд, барааны өрөлт байршил түүний үндсэн дүрмүүд, барааны хаяглалт, түүний стандарт сэдвүүдээр нийт 9 сумын 126 иргэн, аж ахуйн нэгжийн төлөөллийг хамруулан сургалт зохион байгууллаа.

Аяны хаалтын арга хэмжээний үеэр “Хүүхдэд ээлтэй байгууллага”-аар “Сэлэнгийн мэдээ” сонин, “Таны Сэлэнгэ” ТВ, “Шилдэг сэтгүүлч”-ээр “Миний Монгол” КаТВ-ээс “Шилдгийн шилдэг хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлсэн байгууллага”-аар “Хамгийн их үр дүнтэй үйл ажиллагаа явуулсан байгууллага”-аар “Хас” банк, аймгийн Онцгой байдлын газар, “Шилдэг эцэг, эхийн зөвлөл”-аар аймгийн Боловсролын газар, “Хуст хан”, “Цахим ертөнц” ХХК, “Хүмүүсийн сэтгэлд хүрсэн үйл ажиллагаа явуулсан байгууллага”-аар “Шинэ Бадрах” ХХК тус тус шалгарлаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас сумын Засаг даргын Тамгын газар, орон нутагт төрийн үйлчилгээг үзүүлдэг төр төсвийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийн, төрийн албан хаагчдын чадавхийг сайжруулж, орон нутгийн төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Сайхан суманд аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэгийг зохион байгууллаа.

Эрчим хүчний яамнаас эрх шилжиж ирсэн аймгийн 9 сумдад 0.4 кВ-ын шугамын өргөтгөл, шинэчлэлт хийх 900 сая төгрөгийг сумдад хуваарилах, техникийн нөхцлийг боловсруулах, зургийн даалгаврыг бэлтгэх, батлуулах, зураг төсөв хийлгэх зэрэг ажлыг зохион байгууллаа.

Бусад ажлын талаар:

Мэргэжлийн хяналтын газар:

Аймгийн хэмжээнд 63 улсын байцаагч хэрэгжилтийг хангуулж, төрийн хяналт шалгалт, зөвлөн туслах ажлыг хийж гүйцэтгэж байна. Их эрсдэлтэй гэж үнэлэгдсэн 377 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт, 277 объектод зөвлөн туслах үйлчилгээ, 31 чиглэлээр тандалт судалгаа, 14 чиглэлээр хяналт шинжилгээний ажлууд хийж ажиллахаас эхний 5 сарын байдлаар удирдамжийн 238 объектод төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулсан. Улсын байцаагчаас 189 удаагийн мэдэгдэх хуудас, 182 хяналт шалгалтын хуудас, 193 хяналт шалгалтын тэмдэглэл, 103 албан шаардлага, 55 акт, 199 дүгнэлт гаргаад байна. Хяналт шалгалтаар 531 зөрчил илрүүлж зөрчил арилгуулах арга хэмжээ авч, 22936.0 мянган төгрөгийн торгууль, нөхөн төлбөр ногдуулсны 17 сая төгрөгийг бүрэн барагдуулсан.

Гарал үүслийн гэрчилгээгүйгээр мод, модон материал тээвэрлэсэн Сүхбаатар, Алтанбулаг сумын 2 иргэнээс 23.1м³ мод, модон материал хурааж, улсын орлого болгон 2061.5 мянган төгрөгийн торгууль, шийтгэвэр ногдуулж, барагдуулсан.

Хууль бус ан агнууртай тэмцэх “Хавар” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж Цагааннуур, Сүхбаатар сумын нутаг дэвсгэрт хориглосон хугацаанд бор гөрөөс агнасан тус бүр 1 зөрчлүүдийг илрүүлж 1704.0 мянган төгрөгийн нөхөн төлбөр торгууль ногдуулж барагдуулсан.

Зүүнбүрэн, Баруунбүрэн сумдын төр төсвийн 7 байгууллагуудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, эрсдлийн үнэлгээ тооцон, бүртгэл хөтлөлт, төсвийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой 18 зөрчил илрүүлж 7419.0 мянган төгрөгийн торгууль тавьсан.

Тайлант сард итгэмжлэгдсэн лабораторит нийт 273 аж ахуйн нэгжийн 796 дээжинд 4537 үзүүлэлтээр шинжилгээ хийхэд 274 дээж буюу нийт шинжилсэн дээжийн 34.5 хувь нь эрүүл ахуйн шардлага хангаагүй байгаад дүгнэлт гаргаж ажиллалаа.

Онцгой байдлын газар:

Баянгол сумын Аврах, гал унтраах 40 дүгээр ангийн ажилчдын 8 айлын орон сууцыг ашиглалтанд оруулан, нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, онцгой байдлын хурандаа Т.Дуламдорж, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга онцгой байдлын дэд хурандаа М.Энх-Амар болон албаны төлөөлөгч нар оролцлоо.

Аймгийн Засаг даргын баталсан “Хавар” нэгдсэн арга хэмжээний дагуу аймгийн нийт сум, тосгодод үйл ажиллагаа явуулж буй төр, төсвийн болон бусад чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагад Гамшгаас хамгаалах болон Галын аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, норм, стандартын хэрэгжилтийг шалгах удирдамжийн дагуу хяналт шалгалтыг зохион байгууллаа.

“Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуй нэгж, байгууллагад гамшгаас хамгаалах, гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх

төлөвлөгөөт шалгалтын удирдамж"-ийн хүрээнд 151 объект, аж ахуйн нэгж, байгууллагуудад гамшгаас урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, 670 зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 114, мэдэгдэл 30, хууль тогтоомж, дүрэм, журам зөрчсөн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн шаардлагыг хэрэгжүүлээгүй 6 аж ахуйн нэгж, байгууллагыг 1400.0 мянган төгрөгөөр, 2 албан тушаалтныг 100.0 мянган төгрөгөөр, 1 иргэнийг 50.0 мянган төгрөгөөр торгож захиргааны арга хэмжээ ногдуулсан.

“Боловсролын байгууллагууд /МСҮТ, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг/-д Гамшгаас хамгаалах болон Галын аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, норм, стандартын хэрэгжилтийг шалгах төлөвлөгөөт шалгалтаар 24 байгууллагыг хамруулж, 287 зөрчил дутагдал илрүүлэн, хяналт шалгалтын явцад 6 зөрчил дутагдлыг арилгуулан үлдсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн эрх зүйн баримт бичиг 24-ийг үйлдэн аж ахуйн нэгж, байгууллагад өгч ажилласан.

Стандартчилал хэмжил зүйн хэлтэс:

“Дэлхийн хэмжил зүйн өдөр”-ийг угтан аймгийн Стандартчилал хэмжил зүйн хэлтсээс 2014 оны 05 сарын 09-ний өдөр Баянгол суманд “Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангуулах, нутгийн захиргааны болон төрийн байгууллагуудын харилцаа, ажлын уялдаа холбоог сайжруулах, иргэд, аж ахуйн нэгжид хэмжил зүйн ажил үйлчилгээний талаар мэдээлэл, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх, цахилгааны тоолуураар хийж байгаа төлбөр тооцоо, түүний баталгаажуулалттай холбоотой сэдвээр “Цахилгаан эрчим хүч хэрэглэгчдийн өдөрлөг”-ийг ДСЦТС ХХК-тай хамтран зохион байгуулж, иргэд хэрэглэгчдийн санал хүсэлт, гомдлыг сонсож, 2 байгууллагын үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч, хэрэглэгчдээс гаргасан санал, гомдлыг шийдвэрлэх арга хэмжээг зохион байгууллаа.

Сайхан, Мандал сумын 14 ШТС-ын 40 гаруй ажилчдад “Шатахуун түгээх станц Техникийн ерөнхий шаардлага MNS 4623:2013”, “Шатахуун түгээгүүр, шалгах арга хэрэгсэл MNS 3015-97” стандартаар мэдээлэл хийлээ.

Тус хэлтсийн хамт олон аймгийнхаа бүтээн байгуулалт, хотын тохижилт, соёлжилтийг сайжруулахад өөрсдийн хувь нэмрээ оруулах санал санаачлага гарган, Сүхбаатар сумын “Буян арвижих” хийдийн гадна талбайг тохижуулж, явган хүний 69 м² зам тавьж, ногоон байгууламжтай болгох зорилгоор мод тарьж, зүлэгжүүлэх ажлыг хийлээ.

Сүхбаатар, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг, Жавхлант, Баянгол, Мандал, Орхонтуул, Баруунбүрэн сумдын 56 худалдаа, нийтийн хоолны газарт тохирлын үнэлгээ хийснээс мөрдвөл зохих стандартын 84.0 хувиас дээш хувийг хангасан 42 үйлчилгээний газарт тохирлын гэрчилгээг шинээр олгох, хугацааг сунгах саналыг тухайн сумын баталгаажуулалтыг орон тооны бус салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргууллаа.

Мандал, Шаамар, Сүхбаатар, Ерөө, Алтанбулаг сумдын 5 аж ахуйн нэгж иргэний 5 нэрийн 7 бүтээгдэхүүнийг сайн дурын баталгаажуулалтанд хамруулж, итгэмжлэгдсэн лабораторийн сорилт, шинжилгээний дүнг үндэслэн шинжээчийн дүгнэлт гаргалаа.

“Алтан тариа” ХХК-ий БНХАУ-д экспортлож буй 240 тн буудайн хивэгийг тохирлын баталгаажуулалтанд хамруулж, экспортын тохирлын гэрчилгээ олгосон.

Хоёр.Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

4-р сарын 30-ны байдлаар

/мянган төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Орон нутгийн төсвийн нийт	4797844.3	4592074.0	95.7

	орлого			
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	3889783.2	3808632.8	97.9
2	Орон нутгийн төсвийн нийт зарлага	24121470.70	19074933.30	79.1
	Үүнээс: Аймгийн төсвийн зарлагын дүн	3534966.80	2103486.50	59.5
	- Аймгийн ОНХСангийн зарцуулалт	1348000.90	46815.80	3.5
3	Улсын төсвөөс олгосон ОНХСангийн орлогын шилжүүлэг	3139100.00	1038317.00	33.1
4	Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг	1980600.00	1980600.00	100.0
5	Улсын төсвөөс олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	14006278.10	14006278.10	100.0
	Боловсролын салбарт	11182076.30	11182076.30	100.0
	- Эрүүл мэндийн байгууллага	1413368.40	1413368.40	100.0
	Соёл, спорт, аялал жуулчлалын байгууллага	1243547.40	1243547.40	100.0
	- Газрын харилцаа кадастрын алба	70107.80	70107.80	100.0
	- Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс	97178.20	97178.20	100.0
6	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	3585843.70	3585843.70	100.0
7	Байгууллагад олгосон тусгай зориулалтын шилжүүлгийн нийт дүн	14006278.10	14006278.10	100.0
	- Боловсролын салбар	11182076.30	11182076.30	100.0
	- Эрүүл мэнд	1413368.40	1413368.40	100.0
	- Соёлын байгууллага	976929.50	976929.50	100.0
	Газрын харилцаа БХБгазарт	70107.80	70107.80	100.0
	Хүүхэд, гэр бүл хөгжлийн хэлтэст	97178.20	97178.20	100.0
	- Биеийн тамир спортын байгууллага	266617.90	266617.90	100.0
8	Засаг даргын нөөц	203040.00	150158.10	74.0

2014 оны төсвийн гүйцэтгэлийн 4 сарын мэдээгээр орон нутгийн төсвийн орлого 95.7 хувь, улсаас авах санхүүгийн дэмжлэг 100.0 хувь, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 33.1 хувь, салбарын байгууллагуудын тусгай зориулалтын шилжүүлэг 100.0 хувь тус тус биелэгдсэн байна. Төсвийн зарлагын гүйцэтгэл 79.1 хувийн биелэлттэй байна. Аймгаас олгох сумдын санхүүгийн дэмжлэг 100 хувь, Засаг даргаас олгох нөөц хөрөнгийн гүйцэтгэл 74.0 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

№	Барааны нэр, төрөл	Хэмжих нэгж	Үнэ, ханш /төгрөгөөр/	
			2013 оны 5-р сар	2014 оны 6-р сар
Нэг.Талх, гурил, будаа				
1	Гурил /1-гурил/	1 кг	900	1100
2	Талх /орон нутгийн/ том, жижиг	ш	900, 2000	900, 2000

3	Нарийн боов	1 кг	1900-2500	1900-2500
4	Элсэн чихэр	1 кг	2000	2000
5	Цагаан будаа	1 кг	2200	2200
Хоёр.Мах, махан бүтээгдэхүүн				
6	Хонины мах	1 кг	8000	8500
7	Үхрийн мах	1 кг	9000	9500-10000
8	Адууны мах	1 кг	7500	8000
9	Ямааны мах	1 кг	7000	8000
10	Дотор мах цувдай	1 кг	4000	5000
11	Хиам, чанасан	1 кг	9000	9000
12	Гахайн мах	1кг	8000	8000
Гурав.Сүүн бүтээгдэхүүн				
12	Сүү /задгай/	1л	1200	900-1000
13	Сүү /савласан/	1л	2200	2500
14	Тараг /задгай/	1л	1100	1000
15	Хорхой ааруул	1 кг	8000	8000
16	Айраг	1л	-	-
17	Хуурай сүү /орос/	1 кг	4200	4200
18	Өндөг	ш	400	400
Дөрөв. Бүх төрлийн өөх тос				
19	Ургамлын тос	1 кг	2900-3500	2900-3500
20	Өөхөн тос	1 кг	1200	1500
21	Шар тос	1 кг	6000	7000
22	Масло /задгай/	1 кг	3200	3300
Тав.Хүнсний ногоо				
23	Төмс/Монгол/	1 кг	800	1000
24	Лууван /БНХАУ/	1 кг	1200	1500
25	Манжин	1 кг	2000	2000
26	Байцаа /БНХАУ/	1 кг	1500	1500
27	Сонгино /БНХАУ/	1 кг	2000	2000
28	Өргөст хэмх /Монгол/	1 кг	-	-
29	Тарвас /Монгол/	1 кг	-	-
30	Өргөст хэмх /даршилсан/	ш	3200-4000	3500
31	Алаг салат /даршилсан/	ш	1900-2500	1900-2500
Зургаа.Тээвэр шатахуун				
32	Бензин А-80	1 л	1590	1590
33	Бензин А-92	1 л	1690	1690
34	Дизель түлш	1 л	1830	1830

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

1. Архивын талаар:

Сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс агентлагийн 2011-2013 оны баримтын эргэлтийн хэмжээ, архивын баримтын тоо хэмжээ, цахим хэлбэрт шилжүүлсэн баримтын тоо, архив албан хэрэг хөтлөлтийн ажлыг хавсран гүйцэтгэдэг болон дангаар хариуцсан ажилтаны талаарх судалгааг авч нэгтэн мэдээллийн бааз үүсгэж, мэдээллийг Архивын ерөнхий газарт хүргүүллээ.

Жавхлант сумын ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захигааны 1976-1999 оны 169 хадгаламжийн нэгжид иж бүрэн нягтлан шалгалтын ажлыг хийж

дансны бүрдэл болох түүхчилсэн лавлах, нэр төрлийн заагуур, шилжүүлэх хүснэгт, баримтын түүх, ном зүйн жагсаалт, сэлбэн засах болон тоон хэлбэрт шилжүүлэх баримтын судалгаа, устгах хэргийн жагсаалтуудийг хийлээ.

2013, 2014 онд нягтлан шалгалт хийгдсэн хөмрөгүүдийн дансны шинэчилсэн бүртгэлүүд, Стандартчилал, хэмжилзүйн хэлтсийн хадгалах хугацаа дууссан баримтын устгах бичгийн жагсаалт, Хөдөлмөрийн хэлтсийн дэргэдэх баримт бичиг нягтлан шалгах комиссын дүрэм, байгууллагын архивын дүрэм нийт 9 асуудлыг Баримт бичгийн нягтлан шалгах арга зүйн комиссын хурлаар хэлэлцүүлж баталгаажууллаа.

Барилга угсралтын конторын 1981-1992 оны 9 хавтас цалингийн баримтыг төрийн архивт хүлээн авч хөмрөгт байрлууллаа.

Мастер хувиас Зэлтэр сангийн аж ахуйн хөмрөгийн 1976-1992 оны 30 хадгаламжийн нэгжийн 5104 хуудас баримтыг Photoshop программ ашиглан ашиглалтын хувь үүсгэлээ.

Жавхлант сумын ахуйн үйлчилгээний төвийн 7 хадгаламжийн нэгж, аймгийн Улсын банкны конторын 17 хадгаламжийн нэгжид эрдэм шинжилгээ, техник боловсруулалтын ажлыг хийж нийт 1973 хуудас баримтыг сканерт оруулж мастер хувь үүсгэлээ.

Төрийн архивын AMS программд Зүүнхараа сангийн аж ахуйн хөмрөгийн 16 хадгаламжийн нэгжийн 7680 хуудасны мэдээллийн агуулгын 9812 заалт, 20923 хүний нэр, 10049 байгууллагын нэр, 845 газар зүйн нэрийг шивж орууллаа.

Иргэд, албан байгууллагын гаргасан хүсэлтийн дагуу архивын хуулбар 180, цалингийн тодорхойлолт 7, магадлагаа 100, тодорхойлолт 55-ыг гаргаж үйлчиллээ.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1. Боловсролын чиглэлээр:

2013-2014 оны хичээлийн жилийн төрөлжсөн хичээлийн олимпиадын 3-ын даваанд аймгаа төлөөлөн оролцсон багш нараас түүх нийгмийн ухааны хичээлээр Сүхбаатар сумын 3 дугаар сургуулийн багш Б.Далайсүрэн 1 дүгээр байр алтан медаль, биологийн хичээлээр Сүхбаатар сумын 6 дугаар сургуулийн багш Г.Нарантуяа 2 дугаар байр мөнгөн медаль, сурагчдаас түүх, нийгмийн ухааны хичээлээр Сүхбаатар сумын 4 дүгээр сургуулийн 11 дүгээр ангийн сурагч Т.Лхамсүрэн 1 дүгээр байр алтан медаль хүртсэн амжилтуудыг үзүүллээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийн дагуу “Үндэсний бичиг үсгийн өдөр”-ийг аймгийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд төрийн албан хаагчдын дунд монгол бичгийн уралдааныг 3 дахь жилдээ зохион байгууллаа.

Аймгийн боловсролын газраас 2014 оны 05 сарын 09, 10-ны өдрүүдэд “Монгол бичгийн хичээлд мэдээлэл харилцааны технологийг ашиглах нь” сэдэвт сургалтыг зохион байгуулж, Сүхбаатар сумын ерөнхий боловсролын сургуулиудын монгол хэл, уран зохиолын багш нарыг хамрууллаа.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын дунд зарласан “Хүүхэд бүрийн хөгжилд нөлөөлөхүйц сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэж, орчин бүрдүүлэх 2 сарын аян”-ыг дүгнэж Сүхбаатар сумын 3, 4, Сайхан сумын 20, 24, Цагааннуур, Ерөө сум, Мандал сумын Олимп, Нархан Номгон, Дулаанхаан тосгоны цэцэрлэг шалгарч, шалгарсан 10 цэцэрлэгийн төлөөлөгчийг 2014 оны 05 сарын 19-нд Хэнтий, Дорнод аймагт туршлага судлуулах ажлыг зохион байгууллаа.

Койкагийн сайн дурын нийгэмлэгт эмч, компьютерийн багш, Жайка олон улсын байгууллагад биеийн тамирын багш ажиллуулах хүсэлтийг аймгийн Боловсролын газраас тавьж тухайн байгууллагаас сайн дурын гишүүн Соли, компьютерийн багш Нури, сагсан бөмбөгийн багш Такаюки нартай 2 жилийн хугацаанд хамтран ажиллахаар боллоо.

2. Эрүүл мэнд, биеийн тамирын талаар:

Аймгийн Эрүүл мэндийн газраас “Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчин өмнөх оны мөн үетэй харьцуулахад тоон тохиолдлоор нэмэгдсэн байдалд дүгнэлт хийж эрт илрүүлэлт, оношилгоо, эмчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах” чиглэлээр аймгийн 14 сум, 5 тосгоны нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн эрүүл мэндийн талаар хийж хэрэгжүүлж байгаа ажил үйлчилгээтэй танилцан, иргэд, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулж, эрүүл мэндийн байгууллагуудын үзүүлж буй тусламж, үйлчилгээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, ээлтэй орчин бүрдүүлэх зорилгоор “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй эмнэлэг” шалгаруулах болзолт уралдааныг аймгийн хэмжээнд зарлаж, дүгнэлээ.

Аймгийн Эрүүл мэндийн газраас Эрүүл мэндийн сайдын 2014 оны 217 тоот “Эрүүл мэндийн довтолгоо”, “Өрх бүрт хэвшүүлэх 21 дадал”-ыг ард иргэдэд сурталчлах зорилгоор “Эрүүл амьдралын төлөө хамтдаа” сэдэвт долоо хоногийн аяныг Сүхбаатар сумын 4-р багийн 450 гаруй айл, өрх ард иргэдийн дунд зохион байгууллаа.

Тус аймагт ажиллаж буй гадаадын иргэдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах зорилгоор Сайхан сумын “Цемент Шохой” ХК, Ерөө сумын “Болд төмөр Ерөөгол” ХХК, “Өнгөт хийц” ХХК-иудын нийт 230 иргэдийг үзлэг шинжилгээнд хамруулан, шинжилгээнд өөрчлөлттэй 9 хүний хариуг /тэмбүү-1, сүрьеэ-1, В вирус-5, С вирус-2/ холбогдох байгууллагад мэдэгдлээ.

Аймгийн Эрүүл мэндийн газраас “Сэтгэл шингэсэн харилцаа, сэтгэлд нийцсэн үйлчилгээ” сэдэвт сургалтыг Сант сум Хэрх, Дулаанхаан тосгонд бүсчлэн зохион байгуулж, эрүүл мэндийн байгууллагуудын сувилагч, тусгай мэргэжилтэн, туслах ажилтан нарын 130 гаруй хүнийг хамрууллаа.

3. Нийгмийн даатгалын талаар:

Нийгмийн даатгалын сангуудад 7242.8 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл оруулах төлөвлөгөөтэйгээс 6897.6 сая төгрөг хурааж, төлөвлөгөөний биелэлт 95.2 хувьтай байна.

Тайлант хугацаанд тэтгэврийн даатгалын сангаас 17001 тэтгэвэр авагчид 12.4 тэр бум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангаас 3132 даатгуулагчдын хөдөлмөрийн чадвар түр алдалтад 114.6 сая төгрөг, 842 даатгуулагчдад жирэмсэн амаржсаны тэтгэмжид 372.1 сая төгрөг 300 даатгуулагчид 180 сая төгрөгийг оршуулгын зардалд олголоо.

Эрүүл мэндийн даатгалын сангаас нийт 9 эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн 32077 хүний эмчилгээний зардалд 965.9 сая төгрөг, 30 эмийн сангаар үйлчлүүлсэн 3398 даатгуулагчийн эмийн үнийн хөнгөлөлтөнд 22.1 сая төгрөгийг шилжүүлээд байна.

Дөрөв ба түүнээс дээш тооны хүүхэд төрүүлж өсгөсөн, эсхүл олон жил ажилласан нөхцлөөр нас харгалзахгүйгээр, хөдөлмөрийн хэвийн бус нөхцлөөр тэтгэврийн наснаас өмнө 1991-1994 онуудад тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагчдийн ажилласан хугацаа, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцуулах 254 тэтгэвэр авагчдын материалыг хүлээн аваад байна.

Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуульд хамрагдаагүй хоцорсон иргэдийн материалыг 2014 оны 06 сарын 01 хүртэлх хугацаанд хүлээн авч байгаатай холбогдуулан урьдчилсан мэдээгээр 1500 иргэн шинээр бүртгүүлээ.

4. Нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 3074 иргэнд 1640642.2 мянган төгрөг, нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмжинд 1131 иргэнд 319465.1 мянган

төгрөг, ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламжинд 2568 иргэнд 103203.8 мянган төгрөг, амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламжинд 889 иргэнд 230857.3 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 506 иргэнд 48303.9 мянган төгрөгийн тусламж хөнгөлөлт үйлчилгээг тус тус үзүүллээ.

Эхийн алдар одонтой 8394 эхэд 547143.2 төгрөг, жирэмсэн, хөхүүл нярай хүүхэдтэй 2982 эхэд 482383.6 төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 52 иргэнд 10281.1 мянган төгрөг, алдар цолтой ахмадуудад үзүүлэх хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнд 43 иргэнд 33320.0 мянган төгрөгийг тус тус олголоо.

“Хүнсний эрхийн бичиг” олгох журмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааны 1 дүгээр түвшинд багтсан 342 өрхийн 2163 иргэнд 31680.0 мянган төгрөгийн цаасан болон цахим эрхийн бичиг олгох бэлтгэл ажлыг хангаад байна.

5. Хөдөлмөр эрхлэлтийн талаар:

2014 оны 4 сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 845 хүн байсан бол 74 иргэн шинээр бүртгүүлж, ажил олгогчоос ирүүлсэн 52 ажлын байранд 45 хүнийг ажилд зуучилж ажилгүйчүүдийн тоо 874 боллоо.

Аймгийн Хөдөлмөрийн хэлтэс Мандал, Баянгол, Жавхлант, Сайхан сумдын Засаг даргын тамгын газар, ажил олгогчидтой хамтран ажлын байрны өдөрлөг уулзалтыг зохион байгуулж, хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдсан иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр үзэсгэлэн гаргаж 908 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өглөө.

Аймгийн Хөдөлмөрийн хэлтсээс Баянгол сумын Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт хамрагдаж байгаа иргэдэд тусгайлан бэлтгэсэн хөтөлбөрийн дагуу Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ болон Хөдөлмөрийн харилцаа, аюулгүй ажиллагааны сургалтыг зохион байгууллаа.

Шаамар суманд зөгийчин мэргэжлээр 17 иргэн, Бугант тосгонд худалдагч мэргэжлээр 15 иргэнийг мэргэжил олгох түр сургалтанд хамруулан ажиллаж байна. Баянгол, Мандал сумдын 10 иргэнийг шавь сургалтанд сургаж байна.

6. Хүүхэд залуучуудын талаар:

Монгол оронд Хүүхдийн хөдөлгөөн, байгууллага үүсч хөгжсөний 89 жилийн ойн өдрийг “Хүүхдээ дэмжье” уриан дор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс, Мандал сумын Хүүхдийн ордонтой хамтран зохион байгуулж, нийт 57 хүүхэд 25 эцэг эхчүүдэд сургалт зохион байгуулж бүтээлч хүүхдүүдийн үзэсгэлэн гарган, үзэсгэлэнд 13 хүүхэд 3 багш 500 бүтээлээ гаргалаа.

Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс, Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс хамтран “Нээлттэй хаалга”-арга хэмжээг Сүхбаатар суманд зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс, Дэлхийн Зөн Монгол олон улсын байгууллага хамтран “Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил”-ийн хүрээнд Олон улсын гэр бүлийн өдрөөр “Гэр бүлийн үнэ цэнэ” аймгийн зөвлөгөөнийг зохион байгууллаа.

Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:

2014 оны 05 сарын 26-ны байдлаар аймгийн хэмжээнд 112.2 мянган га-д үр тариа, 426 га-д тэжээлийн ургамал 16.6 мянган га-д тосны ургамал нийт 129.2 мянган га-д тариалж, 88.6 хувьтай тариалалт явагдаж, 1940 га-д төмс, 1235 га-д хүнсний ногоо тариалж, хүлэмжинд 31 нэр төрлийн хүнсний ногоо тариалж, үр тариа 90.7 хувь, төмс, хүнсний ногоо 52.2-56.6 хувьтай явагдаж байна.

Аймгийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газраас сумдын жимс, жимсгэний тариалсан талбайн тооллого, газар тариалангийн салбарын талаар гарсан төсөл,

хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж байна.

Энэ онд 1 га-д чавга, 1 га-д үхрийн нүд, 26.7 га-д чацаргана тариалж, жимс жимсгэний нэр төрлийг олшруулах зорилгоор 11 аймгийн 14 сумд 2010 оны 60 дугаар өдөр батлагдсан "Чацаргана" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Чацарганы нөөцөө цууцуйд олгох" төслийн сонгон өдөрхононд 8 сумын 14 аж ахуйн нэгж, иргэд, 17.6 мянган чацарганы суулгацыг эргэн төлөгдөх нөхцлөөр 3 жилийн хугацаатай олгоод байна.

Аймгийн Үйлдвэр хөдөө аж ахуйн газар, "ADRA" Олон Улсын байгууллагатай хамтран "Төмс, хүнсний ногооны технологи"-ийн үзүүлэх сургалтыг газар тариалан, хүнсний ногооны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Сүхбаатар сумын иргэдэд үзүүлэх сургалтыг зохион байгууллаа.

Бог мал ангилалтын үзүүлэх сургалтыг 2014 оны 5 сарын 16-нд Ерөө суманд зохион байгуулж, аймгийн 14 сумын Хөдөө аж ахуйн тасгийн мал зүйчид хамрагдлаа.

Байгаль орчинд халгүй аргаар бэлчээрийн болон тариалангийн талбайн төлөө үндэсний ажиллагааг үйлдэх ажиллагааг нэгж, талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх" ажлын туслан гүйцэтгэгч, газрын даамал нарын үйл ажиллагааг уялдуулах, газар дээр нь үзэж тодруулан шаардлагатай мэдээ мэдээллээр хангах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Зургаа. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын чиглэлээр:

1. Газрын харилцааны талаар:

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар хамтран 2014 оны 05 сарын 18-26-ны хооронд Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтнүүд, сумдын газрын даамлуудад сургалт зохион байгууллаа.

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар хамтран Баянгол, Мандал сумдад ажиллаж "Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх" ажлын туслан гүйцэтгэгч, газрын даамал нарын үйл ажиллагааг уялдуулах, газар дээр нь үзэж тодруулан шаардлагатай мэдээ мэдээллээр хангах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гэр хороололын айл өрхүүдийг дулааны болон цэвэр усны шугамаар холбох ажлын тендерт "Ниншин илч" ХХК шалгарч шугамын ажил эхлэх бэлтгэл ажлын хүрээнд трассын шугамын хамгаалалтын зурваст байрлаж байгаа 8 айлд ажил эхлэх талаар газар дээр очин мэдэгдэл хийлээ.

2. Барилга хот байгуулалтын чиглэлээр:

Баруунбүрэн сумын Амарбаясгалант хийдэд баригдсан нийтийн ариун цэврийн барилга байгууламж, спорт заалны барилга дээр хяналт тавьж, заавар зөвлөгөө өглөө.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтэс, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын хамтарсан ажлын хэсэг Бугант тосгоны захирагчийн албаны барилгын үлдэгдэл ажлыг газар дээр нь үзэж, дүгнэлт гаргалаа.

Түшиг сумын хайрган хучилттай авто замын ажлыг "Сэлэнгэ Есөн Эрдэнэ" ХХК гүйцэтгэж байнгын ашиглалтанд орууллаа.

Мандал сумын Спиртын 40 айлын орон сууцны барилга дээр улсын комисс ажиллан үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд хүлээн авлаа.

Долоо. Сум орон нутгийн талаар:

1. Алтанбулаг сум:

2014 оны 04 сарын 23-нд тус сумын Шатрын Алаг морьт клубын 10 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлж, шатрын тэмцээн зохион байгуулж, Сэлэнгэ бэлчирийн

бүсийн ерөнхий боловсролын 9-н сургуулийн 106 хүүхэд 5 насны ангилалд идэвхитэй оролцлоо.

Тус сумын Засаг даргын бүх нийтээр мод тарих захирамжийн хүрээнд жил бүрийн 5 сарын 10-ны өдрийг “Мод тарих үндэсний өдөр” болгон төр, төсвийн байгууллагуудын ажилчин албан хаагчид, ард иргэд өргөнөөр оролцон мод тарьж ногоон байгууламж бий болголлоо.

Сумын Засаг даргын А/60 тоот захирамжийн хэрэгжилтийг хангаж тус сумын Засаг даргын Тамгын газраас Хүнсний тухай хууль, Ариун цэврийн тухай хуулиудын хэрэгжилтийн талаар сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хүнсний дэлгүүр болон нийтийн хоолны газруудад хяналт шалгалт хийлээ.

Аймгийн Эрүүл мэндийн газар, тус сумын Засаг даргын Тамгын газар хамтран 2014 оны 05 сарын 13-ны өдөр “Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчин эмгэг үүсгэх эрсдэлтэй зан үйлийг бууруулъя” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. УИХ-ын гишүүн С.Баярцогт 05 сарын 20-ний өдөр Алтанбулаг сумын иргэдтэй уулзалт хийлээ. Уг уулзалт сумын соёл мэдээллийн төвд болж 60 гаруй иргэд хөдөлмөрчид оролцсон.

2.Баянгол сум:

Тус сумын Засаг даргын Тамгын газар, аймаг, сумын Улаан загалмайн хороо хамтран “Хүмүүнлэгийн үйлсийн манлайлал” аяныг төр, төсвийн байгууллага, аж ахуйн нэгжийн дунд зараллаа.

2014 оны 05 сарын 09-ний өдөр Баянгол сумын Засаг даргын Тамгын газраас “Мал аж ахуйн салбарт ажиллагсдын зөвлөлгөөн”-ийг зохион байгууллаа. Зөвлөгөөнд урилгаар аймгийн ҮХААГ-ын дарга Х.Даваахүү, Баг сумдын үндэсний холбооны тэргүүн С.Сувдаа нар, 3 багийн малчин, мал бүхий 120 иргэд оролцон сумынхаа мал аж ахуйн салбарт олсон ололт амжилт, алдаа дутагдал, цаашид баримтлах бодлого чиглэл, арга хэмжээний талаар зөвлөлдөж 9 зүйл бүхий зөвлөмж гаргалаа.

2014 оны 05 сарын 22-ны өдөр тус сумын Засаг даргын Тамгын газраас “Ээлтэй үйлчилгээг Баянголчууддаа” уриан дор сумын төрийн албан хаагчдын нэгдсэн сургалт зөвлөгөөнийг зохион байгууллаа. Зөвлөгөөнөөс төр, төсвийн 10 байгууллагын төлөөлөл 100 албан хаагч оролцож 9 заалт бүхий зөвлөмж батлан, мөрдөж ажиллахаар шийдвэрлэлээ.

Сумын хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажил олгогч аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлэх, байгууллагууд хүний нөөцөө бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг сурталчлах зорилгоор “Ажлын байрны өдөрлөг”-ийг аймгийн Хөдөлмөрийн хэлтэс, сумын Засаг даргын Тамгын газар хамтран зохион байгууллаа.

3.Баруунбүрэн сум:

Тус сумын хэмжээнд 9820 га уринш хийснээс 8500 га талбайд улаан буудай 1000 га талбайд рапс, 7 га талбайд арвай, төмс 60 га, хүнсний ногоо 16 га талбайд тус тус тариалаад байна.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас таримал ургамлыг мал тэжээвэр амьтдаас хамгаалах зорилгоор багийн Засаг дарга, аж ахуй нэгж, байгууллагын захирал, эрхлэгч, малчин нар хамтран ажиллах гэрээг боловсруулан баталгаажуулж, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж байна.

Баруунбүрэн сумын Засаг даргын Тамгын газраас сумын төвд байсан хуучин байрны суурь болон зориулалтын бус 2 цэгт хуримтлагдсан 1200 тн хог хаягдлыг цэвэрлэх, суурийг дарж тэгшилэх ажлыг зохион байгууллаа.

4.Ерөө сум:

Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн үзлэг оношлогоо тус суманд 3 өдрийн турш явагдаж, үзлэгийн үеэр 318 иргэн, 6 аж ахуй нэгжийн нийт 773 тээврийн

хэрэгсэл хамрагдаж 56249.8 мянган төгрөгийн татвар, 5170.2 мянган төгрөгийн агаар бохирдлын төлбөр тус тус төвлөрлөө.

2014 оны 05 сарын 10-ны өдөр “Ногоон Сэлэнгэ” аян, “Бүх нийтээрээ мод тарих үндэсний өдөр”-ийг тохиолдуулан сумын төв талбайд төр төсвийн байгууллагын ажилтан албан хаагчид, төрийн бус байгууллагууд, Ахмадын холбоо, Залуучуудын холбоо, Тэнгэрлэг Ерөө ХХК, Мужааны цех, Ахуйн үйлчилгээ, Мянган цагаан туг ХХК, зэрэг 20 байгууллагын нийт 150 гаруй иргэд оролцлоо.

Тус сумын Засаг даргын Тамгын газар, ерөнхий боловсролын 12 жилийн дунд сургууль хамтран сурагчдад “Ой хээрийг түймрээс хэрхэн урьдчилан сэргийлэх” тухай сургалт зохион байгууллаа.

2014 оны 04 сарын 28-аас 05 сарын 23-ны хооронд Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Онцгой байдлын газар, сум дундын Ойн анги, тус сумын Засаг даргын Тамгын газар хамтран хяналтын постыг ажилуулж, иргэдэд “Ой хээрт явахдаа дагаж мөрдөх аюулгүй ажиллагааны зааварчилгаа” болон “Ойн тухай” хуулийн гарын авлага тараалаа.

5. Жавхлант сум:

2014 ий 05 нăдăи 01–і еé өдөр тус сумын Засаг даргын Тамгын газар, àeí æeí ĩ eëäâýð÷í eé ýâeýeëeí холбоо хамтран үeëäâýð÷í eé ýâeýeëeí óóâeé, ĩ eëäâýðeýeëeí î ĩî è, àð óeâĵe àæeëeäæä, ĵeëäâýðeýeëeí î ĩeûí ääàðæeûí óóâeé èðĵăÿä î ýâúeýeë ° ä: сургалт зохион байгууллаа.

Жавхлант сумын Засаг даргын Тамгын газраас “Согтууруулах ундааны хяналтын тухай” хууль, “Àðõeäâí ĩî äðóóðàðòàe òÿì òÿò тухай òóóeĵ”-eëí ð° ĩeĵĵæeëí òÿeýeëĵĵeæeä 2014 ий 05 нăдăи 09–і eé ° äeð ĵî òeî í äeëæóeëä. Õÿeýeëĵĵeÿâ ñòì úí èðĵăÿ, àeäâí ðàâä:èä, ĩî äòóóðóeäð óí ääà ðäâeëäââ äí èî í òĵĵâÿð ĵeë÷eëâÿä àæàðóeí í ýæäâeæðóeëäâĵî ĵàðeðäe, эрхлэгч í äð î ðî eëí æí eëð 72 èðĵăÿî ðàî ðàæeäâ.

Аймгийн Хөдөлмөрийн хэлтэс, тус сумын Засаг даргын Тамгын газар хамтран “Хөдөлмөрийн өдөрлөг”-ийг зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр ажил олгогчдоос сул чөлөөтэй ажлын байрны захиалга авах, өдөрлөгт оролцож буй иргэдтэй уулзаж ярилцан, ажлын байранд бүртгэх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах болон төсөл хөтөлбөрийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа. Өдөрлөгт оролцсон иргэдийн дунд Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиудаар АХА танин мэдэхүйн уралдаант тэмцээн áí èî í æижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн үзэсгэлэнг зохион байгууллаа.

Тус сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, Засаг даргын Тамгын газар, ерөнхий боловсролын сургууль хамтран “Оролцъё-суралцъя-өөрчилъё” уриан дор òĵĵðæeëí ÷óeëæä î ä зохион байгууллаа.

6. Зүүнбүрэн сум:

Тус сумын Засаг даргын Тамгын газраас гэр бүлийн хөгжлийг дэмжих жилийн хүрээнд 2014 оны 05 сарын 10-ны өдөр нээлттэй өдөрлөг зохион байгуулж нийт 20 гаруй иргэд хамрагдлаа.

Тус сумын Засаг даргын 2014 оны А/54 тоот захирамжаар хүндэтгэлийн туг аялуулах тухай 90 хоногийн аяныг зарлаж төр төсвийн байгууллага, аж ахуйн нэгж, багаар аялуулж, 2014 оны 05 сарын 02-ны өдөр “Замд гаръя” спортын арга хэмжээ зохион байгуулж, нийт 150 гаруй эцэг эхчүүд оролцож, тэргүүн байранд Л.Өнөрмаа багштай ахлах бүлгийн “Дэгдээхий” баг тэргүүлж 500.0 мянган төгрөгийн үнэ бүхий сургалтын хэрэглэгдэхүүний батламжыг гардан авлаа.

2014 оны 05 сарын 10-ны өдөр сумын Засаг даргын Тамгын газар, “Бүрэн ургац” хоршоо, ADRA олон улсын байгууллага хамтран сумын ногоочид болон ногоочдын бүлэг, хоршоодод зориулж хүнсний ногоо тариалалт, туршлага судлах чиглэлээр сургалт зохион байгууллаа.

2014 оны 05 сарын 15-ны өдөр Зүүнбүрэн сумын Засаг даргын Тамгын газраас “Хог хаягдлын тухай хууль”, хог хаягдлыг ангилах, ялгах, дахин ашиглах, түүгээр хэрхэн ашиг олж болох талаар сургалт зохион байгуулж, аж ахуйн нэгж, иргэдийн санал бодлыг хүлээн авлаа.

7.1 ай ааё ной :

Тус сумын Засаг даргын Тамгын газраас ерөнхий боловсролын 2-р сургуулийн багш ажилчдад Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжуудын талаар таниулга, Бүтээмж дээшлүүлэх 5 С-ийн зарчмын талаар сургалт зохион байгууллаа.

Мандал сумын Засаг даргын Тамгын газраас 2011, 2012, 2013 онд Сум хөгжүүлэх сангийн зээлд хамрагдсан иргэд, аж ахуйн нэгжүүдтэй уулзаж, үйл ажиллагаатай нь танилцан зээлийн эргэн төлөлтийн явцын талаар сануулга өглөө.

Тус сумын өрхийн тариаланчид нэгдэн “Ногоочдын холбоог байгуулан ажиллаж “Хөдөөг шинэчлэх фермерүүдийн холбоо”-той хамтын ажиллагааг эхлүүлж, төрөл бүрийн ногооны үрийн дэлгүүр ажиллуулахад 1.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж иргэд, хөдөлмөрчдөд чанарын баталгаатай төрөл бүрийн үрээр үйлчилж байна.

Мандал суманд Хэнтий аймгийн Баян-Адрага сумаас туршлага судлахаар ирсэн аялалын багт тус сумын Засаг даргын Тамгын газраас Орон нутаг хөгжүүлэх сан болон Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хийгдсэн бүтээн байгуулалтын ажлуудын талаар мэдээлэл хийж, өрхийн тариалан, жимсний аж ахуй, гахай, шувуу, сүүний үхрийн фермерийн аж ахуй, пакетласан салат, хэрчсэн гурил, бууз банш, бялуу талх нарийн боов, гутал үйлдвэрлэл, оёдол, мах бэлтгэх төв, ноосон бүтээгдэхүүний цех зэргийн үйл ажиллагааг танилцууллаа.

8.Орхон сум:

Тус сумын Засаг даргын Тамгын газраас “Бог малын хээлтүүлэгчийг Мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжид шилжүүлж мэргэжилтний хяналтанд авах болсонтой холбогдуулан танилцуулга гарын авлага бэлтгэн малчдад танилцуулах ажлыг зохион байгуулж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 тоот зарлиг, аймгийн Засаг даргын 2014 оны 04 тоот албан даалгаврын хэрэгжилтийг ханган сумын хэмжээнд ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх, мод бут тарих, байгаль орчныг хамгаалах, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор сумын Засаг даргын 2014 оны А/71 тоот захирамжаар “Нэг иргэн-нэг мод” аяныг 2014 оны 04-р сарын 25-ны өдрөөс 10-р сарын 20-ны хооронд зохион байгуулж 5 байгууллага, 4 аж ахуйн нэгжийн 92 албан хаагч оролцон, нийтийн эзэмшлийн гудамж талбайд 1700 ширхэг хайлаас, 1600 ширхэг улиас, 37 ширхэг чацаргана, үхрийн нүд, бургас, моносны 52 ширхэг, шар хуайс 30 ширхэг, харгана 70 бут, агч 20 ширхэг, шинэс 20 ширхэг зэрэг мод бутыг тарьж суулгалаа.

2014 оны 05 сарын 23, 24-ны өдрүүдэд “Орхон бүс”-ийн Засаг даргын тамгын газрын төрийн албан хаагчдын дунд зохиогддог урлаг, спортын нөхөрсөг уулзалт тэмцээнийг тус суманд зохион байгууллаа.

9.Сант сум:

Тус сумын Засаг даргын 2014 ны А/38 тоот захирамжаар бэлчээрийн хортон мэрэгчидтэй механик аргаар тэмцэх ажлын хэсгийг байгуулан 10 хоногт багтаан зохион байгуулж, 12 портер машин, 12 туслах ажилтан нийт 24 хүн ажиллаж 6000 га талбайд оготно устгалын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас ажлын байр бий болгох жижиг зээлэнд 6 иргэн хамрагдаж 18.0 сая төгрөгийн санхүүжилтийг олголоо. “Ногоон байгууламж 2014” мод тарих нийтийг хамарсан ажлыг 2014 оны 05 сарын 09-19-ний өдрүүдэд

дарга, Засаг даргын орлогч нар сумын ерөнхий боловсролын сургуулийг “Эрдэнэ Чин Ван Намсрайн” нэрэмжит болгох аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолыг гардуулъя.

13.Хушаат сум:

Тус сумын Засаг даргын Тамгын газраас “Орон сууц хөтөлбөр”, “Жишиг фермер, эрчимжсэн мал аж ахуйг дэмжих хөтөлбөр”, “Хамгаалагдсан хөрсний аж ахуйг дэмжих хөтөлбөр”-үүдийг боловсруулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн, батлууллаа.

Сумын Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төв, албан бус боловсролын Насан туршийн боловсрол олгох төв хамтран “Эрүүл зөв амьдралын дадал хэвшил, хэв маяг”, “Эмийн гаж нөлөө, эмийн зохистой хэрэглээ”, “Зөв хооллолт”, “Архи тамхины хор уршиг” сургалт, Согтууруулах ундааны хяналтын тухай хуулийн төсөл”-ийн хэлэлцүүлэгт төр төсвийн байгууллагын албан хаагч, иргэд, аж ахуйн нэгжийн төлөөллийг хамруулан зохион байгууллаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, сумын Засаг даргын Тамгын газар хамтран “Хүний эрхийн тухай” сургалтыг төр, төсвийн байгууллагын албан хаагч, иргэдийн дунд зохион байгууллаа.

14.Хүдэр сум:

Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын улсын үзлэг 2014 оны 05 сарын 17-18 ны өдрүүдэд зохион байгуулагдаж, үзлэгээр нийт 367 тээврийн хэрэгсэл татвараа төлж 11200.0 мянган төгрөгийн орлого орууллаа.

Тус сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг хамтран 2014-2015 оны хичээлийн жилд 1-р ангид элсэн суралцах цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн хүүхдүүдийг сургуультайгаа танилцах аялалыг зохион байгууллаа.

Тайлант сард Малчид, тариаланчдын зөвлөгөөнийг 40 гаруй малчид 15 газар тариалан эрхлэгч, ногоочдыг хамруулан зохион байгуулж, мал аж ахуй газар тариалангийн талаар хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг хэлэлцүүлж, цаашид хийх ажил арга хэмжээний талаар 15 заалт бүхий зорилт дэвшүүлэн гаргалаа.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР